



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн дүрмийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболдыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн бодлогын газар /Ц.Зоригтбат/-т даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

9767000453